

МЕТАЛЛ ХИЙЦЛЭЛИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

..... оны ... -р сарын ... -ний өдөр

Дугаар: ...

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас ... тоот хаягт байрлалтай, тоот регистрийн дугаартай “.....” ХХК (Цаашид “Захиалагч” гэх) түүнийг төлөөлж, Гүйцэтгэх захирал, нөгөө талаасбайрлалтай,тоот регистрийн дугаартай “.....” ХХК (Цаашид “Гүйцэтгэгч” гэх) түүнийг төлөөлж Захирал .. (Хамтад нь “Талууд”гэх) нар Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн харилцан тохиролцож байгуулав.

1. Гүйцэтгэгч нь барилгын дээвэр дээр парпетны метал хашлага, Гадна метал листэн хашаа хийх ажлыг барилгын тухай хууль болон холбогдох норм, дүрэм, Захиалагчийн шаардлагын дагуу хийж гүйцэтгэнэ.
2. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний 1-д заасан ажлыг 2024 оны ... дугаар сарын ... -ний өдрөөс 2024 оны дугаар сарын -ны өдөр хүртэл буюу ... хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.
3. Гүйцэтгэгчийн энэхүү гэрээний 2-д заасан хугацаанд гүйцэтгэх ажлын ажилбар бүрд Захиалагчийн инженер хяналт тавих бөгөөд Гүйцэтгэгч нь Захиалагчийн инженерийн тавьсан шаардлагыг биелүүлж ажиллана.
4. Гүйцэтгэгч тал нь парпетны ажлын бараа материалыг Захиалагч нь Гадна метал листэн хашааны үндсэн материалыг тус тус нийлүүлнэ.
5. Гүйцэтгэгч нь парпетны хашлагыг Захиалагчийн инженерийн заасан хэмжээний дагуу металл фасаданд бэхэлнэ.
6. Гүйцэтгэгч нь бэхэлгээний тогтоох арга, аргачлалыг Захиалагчийн инженертэй зөвшилцөлд хүрсний дараагаар хийнэ.
7. Гадна метал листэн хашааг дараах дарааллын дагуу болон Захиалагчийн инженерийн өгсөн чиглэлийн дагуу хийж гүйцэтгэнэ.
 - a. Хашааны хаалтыг ажлыг хийнэ.
 - b. Лист төмрийн периметрийн дагуу ..квадрат төмрөөр хүрээлж гагнана.
 - c. Хашааны баганыг төмрөөр хийнэ. Төмөрбетон түшиц хананд баганыг таваг төмөр гагнажанкерлаж бэхэлнэ.
 - d.
8. Энэхүү гэрээгээр гүйцэтгэх ажлын нийт төлбөр /.../ төгрөг байна. Дээрх үнийн дүнд парпетны ажлыг гүйцэтгэхтэй холбоотой бараа материалын зардал болон нийт ажлын бэхэлгээ, угсралт суурилуулалтын зардал зэрэг бүхий л зардал болон НӨАТ зэрэг бусад зардал багтсан болно. Дээрх үнийн дүнд Гадна метал листэн хашааны үндсэн материалын зардал ороогүй болно.
9. Гэрээний 7-д заасан төлбөрийг Гүйцэтгэгчийн банкны тоот дансанд дараах байдлаар төлнө. Үүнд:
 - a. Урьдчилгаа төлбөр: ...
 - b. Дундын санхүүжилт: ...
 - c. Сүүлийн санхүүжилт:
 - d. Баталгаа:
10. Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажил нь энэхүү гэрээний Хавсралт 1-д заасан ажлын тоо хэмжээнээс илүү, эсхүл дутуу хийгдсэн тохиолдолд талууд хамтран хэмжиж тооцоо гаргана. Гарсан тоо хэмжээнд үндэслэн анхны өгсөн үнийн саналын нэгж үнэд суурилан төлбөрийг тооцож төлнө.
11. Талууд гэрээт ажлыг бүрэн гүйцэтгэж дууссанаас хойш ажлын 3 хоногт багтаан шалган хүлээн авах бөгөөд Захиалагчийн инженер гүйцэтгэлийн тайлан үйлдэж, актаар баталгаажуулан хүлээн авна.

12. Гэрээт ажлын баталгаат хугацаа 6 сар байна.
13. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг холбогдох норм дүрэм болон энэхүү гэрээний Хавсралт 1-д заасан тоо хэмжээний дагуу Захиалагчийн шаардлагын хүрээнд гүйцэтгэн хүлээлгэн өгнө.
14. Энэхүү гэрээний баталгаат хугацаанд гэрээний үнийн дүнгийн 5% болох төгрөгийг Захиалагч баталгаа хэлбэрээр суутган барьж үлдэнэ.
15. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг энэхүү гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй, Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөөгүй, дутуу төлсөн тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгийн 0.5%-тай тэнцэх хэмжээний алданги төлнө.
16. Гүйцэтгэгч нь гуравдагч этгээдийн хийж гүйцэтгэсэн ажлыг гэмтээсэн, хохирол учруулсан тохиолдолд үүссэн хохирлыг дангаар барагдуулж, Захиалагчийг хохиролгүй болгоно.
17. Гэрээт ажил нь алдаатай, чанарын шаардлага хангахгүй, доголдолтой гэдэг нь тогтоогдсон тохиолдолд Гүйцэтгэгч ажлыг дахин хийж гүйцэтгэнэ. Ийнхүү хугацаа хожимдсон нь энэхүү гэрээний 14 дүгээр зүйлд заасан алданги төлөх үндэслэл болно.
18. Энэхүү гэрээтэй холбоотой аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хэлэлцээрийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Маргааныг хэлэлцээрийн журмаар шийдвэрлэх боломжгүй болсон тохиолдолд Монголын Барилгын Үндэсний Ассоциацийн дэргэдэх Барилга, Дэд бүтцийн Олон Улсын Арбитраар түүний хэрэг хянан шийдвэрлэх дүрмээр шийдвэрлүүлнэ.
19. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, талуудад тус бүр нэг нэг хувийг хадгалуулав.
20. Энэхүү гэрээнд нарийвчлан тусгаагүй харилцааг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хэм хэмжээ болон нийтлэг практикт мөрдөгддөг байдлаар ойлгоно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагч талыг төлөөлж:

.....

Гүйцэтгэгч талыг төлөөлж:

.....

**МЕТАЛЛ ХИЙЦЛЭЛИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭНИЙ
ХАВСРАЛТ №1 АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ**

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ